



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

Г Гэмтэл, согог судлалын үндэсний Төвийн дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг тус Төв (Ц.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан дүрэм, бүтэцтэй холбоотой өмнөх тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

002711

109

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 10 сарын 18 өдрийн
390 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэмтэл согог, судлалын үндэсний төв (цаашид Төв гэх) нь улсын хэмжээнд осол, гэмтэл болон осол, гэмтлийн мэс заслын чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлэх, тухайн чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах лавлагаа төв мөн.

1.2. Төв нь хүн амд тухайн чиглэлээр мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хүн амын дунд осол, гэмтлийн шалтгаант өвчлөлийн тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага болно.

1.3. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.4. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.

1.5. Төв нь Гэмтэл согог, судлалын үндэсний төв, Улаанбаатар хот 16094, Баянгол дүүрэг, 7 дугаар хороо, Чингүүнжавын гудамж-4 гэсэн хаягтай байна.

1.6. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Traumatology and Orthopedics" гэж орчуулна.

1.7. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх,
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах,
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих,
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах,
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах,
- Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах,
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

2.2. Төвийн эрхэм зорилго үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, мэргэжлийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй, цаг хугацаанд нь үзүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй.

3.1.1. Гэмтэл, согог судлалын чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2. Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, материаллаг болон хүний нөөц, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах,

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох,

3.1.4. Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах,

3.1.5. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах,

3.1.6. Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх,

3.1.7. Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх,

3.1.8. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй.

3.2.1. Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд гэмтэл, согогийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношлогоо, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах,

3.2.2. Бусад эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй гэмтэл, согогийн тусламж үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,

3.2.3. Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний санал боловсруулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах,

3.2.4. Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах,

3.2.5. Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх,

3.2.6. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх,

3.2.7. Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чиглэлээр олон нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, холбогдох байгууллагыг арга зүйн удирдлагаар хангаж хамтран ажиллах,

3.2.8. Хүн амын дунд осол, гэмтлийн шалтгаант өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах,

3.2.9. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх,

3.2.10. Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмнэлзүйн судалгаа шинжилгээ хийж, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох,

3.2.11. "Осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах,

3.2.12. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх,

3.2.13. Үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах,

3.2.14. Тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах,

3.2.15. Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр олон улсын түвшний итгэмжлэл авсан байх,

3.2.16. Санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлэх,

3.2.17. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах,

3.2.18. Ажиллагсдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах,

3.2.19. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

4.2. Төвийн Ерөнхий захирал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт эрхэлсэн дэд захирал, стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал болон захиргааны нэгжийн удирдлагыг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.3. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхий захирал батална.

4.4. Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.5. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмэн эмчилгээг зохицуулах хороо, Санал гомдлын хороо болон бусад шаардлагатай зөвлөл, хороод байгуулан ажиллуулна.

4.6. Ерөнхий захирлын эрх, үүрэг:

4.6.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах,

4.6.2. Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын дотоод журам, эрсдлийн удирдлагын журам, ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих,

4.6.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох,

4.6.4. Дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх,

4.6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх,

4.6.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах,

4.6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах,

4.6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах,

4.6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах,

Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1. Улсын төсөв,

5.2. Эрүүл мэндийн даатгал,

5.3. Үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн олсон орлого гэх мэт),

5.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж,

5.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,

5.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

6.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Ерөнхий захирал төлөөлнө.

6.2. Төвийн Ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.

6.4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төвийн тасаг, албадын үйл ажиллагааны ерөнхий чиглэл

7.1. Чанарын алба

Чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавина.

7.2. Санхүү, эдийн засгийн алба

Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авна. Төвийн нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа төсвийн хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцүүлэн, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг ханган ажиллана. Мөн санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3. Стратеги, төлөвлөлтийн алба

Төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулж хэрэгжилтийг хангана. Төвийн дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавина.

7.4. Хангамж, үйлчилгээний алба

Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангана. Гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.

7.5. Инженер, техникийн алба

Төвийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх, зохион байгуулах, засвар үйлчилгээг хийх, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан бүрдүүлж удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.

7.6. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба

Төвийн урт, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Төвийн үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж, мэдээллээр удирдлагыг хангана. Эрсдлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт-шинжилгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж боловсруулж дотоодын болон хөндлөнгийн аудитыг зохион байгуулан ажиллана.

194

7.7. Хүний нөөцийн хөгжлийн алба

Хүний нөөцийн төлөвлөлт, сургалт, хөгжил, байршил, хуваарилалтыг оновчтой зохицуулах, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмч, эмнэлгийн ажилтны ёсзүй, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, хөшүүргийг бий болгоно. Гэмтэл, согогийн чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулна.

7.8. Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны алба

Төвийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, төсөл, стратегийн хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах, осол, гэмтлийн шалтгаант өвчлөлийн түвшин, тархалтыг тогтоох тандалт судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хөтөлбөр, удирдамж боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

7.9. Гадаад харилцааны алба

Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, харилцан туршлага солилцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох ажлыг зохион байгуулж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

7.10. Мэдээллийн технологи, статистикийн алба

Төвийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлж, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлнэ. Үндэсний түвшинд статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, нэгтгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцна. Бусад эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, мэдээллийн технологийн ажилтанд осол, гэмтлийн бүртгэл, мэдээллийн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

7.11. Захирлын ажлын алба

Төвийн Ерөнхий захирлын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль эрхзүйн зөвлөгөө, Төвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

7.12. Хэвтүүлэн эмчлэх тасгууд

Түлэнхий, нөхөн сэргээх мэс заслын тасаг, гар, сарвуу, бичил мэс заслын тасаг, үений эмгэгийн тасаг, насанд хүрэгчдийн гэмтэл, согогийн тасаг, хүүхдийн гэмтэл, согогийн тасаг, хавсарсан гэмтлийн тасаг, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тасаг, тархи, нуруу нугасны гэмтэл, согогийн тасаг.

7.13. Сэргээн засах эмчилгээний тасаг

Гэмтлийн дараах эд эрхтний үйл ажиллагааг сэргээн засах эмчилгээ үйлчилгээ үзүүлнэ.

7.14. Мэс заслын нэгдсэн тасаг

Гэмтэл, согогийн төлөвлөгөөт болон яаралтай мэс заслын бэлтгэл, халдвар хамгаалал, аюулгүй байдал, хагалгааны багаж төхөөрөмжийн болон мэс заслын үеийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэс заслын дараах сэрээх, хянах, шилжүүлэх үйлчилгээг үзүүлнэ.

115

7.15. Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн алба

Цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, сэлбэх, аюулгүй ажиллагааг хангана. Аюулгүй ажиллагааны аргачлалд эмнэлгийн мэргэжилтнийг сургах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийг зохих журмын дагуу бүртгэх, мэдээлэх, сэргийлэх ажлыг зохион байгуулна.

7.16. Эмгэг судлалын хэсэг

Шүүх эмнэлэгтэй хамтран ажиллах, цогцост задлан шинжилгээ хийх бэлтгэл хангах, оношийн зөрүүг тодорхойлох, эмгэг судлалын хурал хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.17. Амбулатори, лавлагааны хэсэг

Гэмтэл, согогийн чиглэлээр амбулаторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлж, санал, хүсэлтийг хүлээн авч, лавлагаа мэдээллээр ханган зохицуулалт хийнэ. Лавлагааны хэсгийн дэргэд хөтөч ажиллуулна. Бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээ үзүүлж, сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.

7.18. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг

Улсын хэмжээнд гэмтэл, согогийн чиглэлээр хүлээн авах, яаралтай тусламж үзүүлнэ.

7.19. Дүрс оношлогооны тасаг

Бүх төрлийн гэмтэл, согогийн рентген, хэт авиа, компьютерт томограф, уян дурангийн оношилгоо хийх, дүрс оношлогооны арга, технологийг нэвтрүүлнэ.

7.20. Лабораторийн тасаг

Лабораторийн ерөнхий болон нарийвчилсан шинжилгээ хийж, гэмтэл, согогийн чиглэлээр эцсийн дүгнэлт гаргана.

7.21. Сувилахуйн алба

Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулан арга зүйгээр хангаж ажиллана.

7.22. Халдвар хяналтын алба

Халдварын хяналт, ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг Төвийн хэмжээнд хийж, эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна.


7.23. Эм зүйн алба

Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнүүдийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.


Найм. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

Төвийн Ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
ерөнхий зураглал



————> Мэргэжил, арга зүйн шууд удирдлага
- - - -> Мэргэжил, арга зүйн шууд бус удирдлага



ГЭМТЭЛ, СОГОГ СУДАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

